

Эх оронч үзэлд суурилсан үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх арга зам

Б.Батбаяр

БХЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөл

Key words:

Motherland, unity,
independence,
valuable heritage,
native language,
history, culture,
ideology, overcome,
adaptation,
resilience.

Abstract: This research article describes the problems and ways to solve them in fostering patriotism in everyone from childhood, increasing the value of citizens' love and defense of their homeland, ensuring national unity, and further strengthening national resilience based on patriotism.

Оршил

Дэлхийн улс орнуудын геополитикийн өрсөлдөөн, хүчирхэг гүрнүүдийн ашиг сонирхлын тэлэлт нь улс төр, эдийн засаг, нийгмийн хүндхэн шинэ сорилт, бэрхшээлүүдийг бий болгож, дэлхийн “Энх тайван” улс үндэстний “Үндэсний эв нэгдэл”, “Эх оронч” сэтгэлгээнд сөргөөр нөлөөлж, улс үндэстний “Оршин тогтнох”-ын баталгааг бууруулж байна. Үүнд - хөгжил буурай, цэргийн чадавх сул, үндэсний эв нэгдэл бэхжээгүй улс орнууд “бэлэн өгөөш” болох эрсдэл үүсэж, түүнийг улс үндэстнээрээ сөрөн тэсвэрлэх, шинэ тутам сорилтыг даван туулах зайлшгүй шаардлагыг бий болгож “Эх оронч үзэлд суурилсан үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх” стратегитай байхыг мөн шаардаж байна.

Монголчууд бидний “Эх оронч үзэл” эрт үеэс өвлөгдөн ирсэн “ҮНЭТ ӨВ” бөгөөд төр улсаа төвхнүүлж, хөгжүүлэх, аливаа сорилт, бэрхшээлийг даван туулах, дасан зохицох чадавх нь эцэг, өвгөдийн эх орон, газар нутгаа хайрлан, гаднын аюул заналхийллээс хамгаалах “ЭХ ОРОНЧ” сэтгэлгээнээс эхтэй юм. Энэ нь улс үндэстнийхээ язгуур эрх ашиг, “Монгол хүний хөгжил, эх оронч ухамсар, хандлага, уламжлалт ахуй, өв соёл, зан заншлыг сурталчлах, соён гэгээрүүлэх” үйл ажиллагааг эрчимжүүлэх, чанарыг дээшлүүлэх үндэс суурь нь болсоор ирсэн билээ.

Түүнчлэн Монголчууд “1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн”-өөр “Эх оронч үзэл”-ээр эвлэлдэн нэгдэж, сөрөн тэсвэрлэх чадавхаа бэхжүүлсний үндсэн дээр Манж Чин улсын 200 гаруй жилийн дарлалаас ангижирч, “Тусгаар тогтнол”-оо сэргээж чадсан нь өнөөгийн Монгол Улсын “Оршин тогтнохын баталгаа” болсон төдийгүй “Эх оронч Монгол хүн” байхын утга учир, эх орноо хайрлах, эцэг, өвгөдийн ариун гал голомтыг

сахин хамгаалахын үнэ цэнийг хойчийн хүүхэд, залууст өвлүүлэн үлдээсэн “Мартах учиргүй” түүхэн явдал байсан юм.

Үүнийг Монголчууд эвлэлдэн нэгдэж, төр улс, төрөлх газар, усаа гэсэн нэгэн үзүүрт сэтгэл, “эх оронч үзэл”-ээр нягтарч чадсан үедээ хүчирхэгжин мандаж, эсрэгээрээ “Үндэсний эв нэгдэл”-ээ алдаж, улс гэрийн эрх ашгаа умартаж, хувийн эрх ашгаа урьтал болгон, өөр зуураа эрх мэдэл, эд баялгаа булаалдан тэмцэлдсэн үедээ бусдын “бэлэн зууш” болж, уруудан доройтож, үндэс угсаагаараа сөнөн мөхөх, цөөрч бүдгэрэх аюулд орж¹ байсныг эх орончдын түүх нотолж байна.

Энэхүү түүхэн туршлага, сургамж нь цаашид улс үндэстнээрээ эе эвийг эрхэмлэн нэг санаа, зорилготойгоор “Эх орон, үндэс угсаа, ололт дэвшлээрээ бахархах, үндэсний ашиг сонирхол, ёс зүй, хууль, төрт ёсны үзлийг дээдлэх үнэт зүйл бүхий нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх ...”²-д онцгой анхаарал хандуулан “Эх оронч үзэлд суурилсан үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх”-ыг бэхжүүлж, тулгамдаж буй дотоод, гадаад олон сорилт, бэрхшээлүүдийг эрсдэл багатай даван туулах чадавхтай байхыг анхааруулж байна.

Түүхийн эх сурвалжаас харахад: бүхий л цаг үед “Эгэл ард түмний эх оронч үзэл, эв нэгдэл” нь улс үндэстний оршин тогтнох, аливаа сорилт, бэрхшээлийг даван туулах гол шалгуур байсан бол “Түүх, эх хэл, соёл, өв уламжлал, зан заншил, хүн бүрийн хүүхэд байхаасаа өвлөн тээсэн ёс суртахуунт ухамсар” нь эх оронч үзлийг түгээн дэлгэрүүлэх механизм нь болж иржээ. Иймд “Эх оронч үзлийг хүн бүрд хүүхэд байхаас нь төлөвшүүлэх” механизмыг сэргээж, эе эвийг эрхэмлэн “Эх оронч” Монгол хүний үнэт сэтгэлгээгээр эх оронч үзлийг түгээн дэлгэрүүлж, аливаа сорилт, бэрхшээлийг даван туулах, дасан зохицох чадавхыг бэхжүүлэх нь зүйтэй юм.

Нэг. “Эх оронч үзэл ба үндэсний эв нэгдэл”

Монгол хүний хамгийн дээд үнэт зүйл нь “Эх оронч Монгол хүн”.

Сүүлийн жилүүдэд дэлхийн аюулгүй байдлын орчин, цэрэг-улс төрийн нөхцөл байдал хурдацтай өөрчлөгдөж, их гүрнүүдийн геополитикийн сөргөлдөөн даамжирч хөрш зэргэлдээ улс орнуудын оршин тогтнохын аюулгүй байдалд олон сорилт, бэрхшээлүүдийг бий болгосоор байна. Өнөө үед явагдаж буй дайн, зэвсэгт мөргөлдөөний туршлага, сургамжаас харахад “Эх оронч үзэлгүй”, “Эх оронч төлөвшилгүй” улс үндэстэн бусдын эрхшээлд орж, харин эх орон, тусгаар тогтнолоо хайрлан хамгаалж, үндэстнийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, улс, эх орныхоо хөгжил, дэвшилд нэгэн сэтгэлээр зүтгэж, аливаа сорилтыг даван туулах чадавхаа бэхжүүлж чадсан

¹ Ч.Эрдэнэчулуун. “Үндэсний эв нэгдлийн тулгамдсан асуудал, бэхжүүлэх зарим асуудалд” өгүүлэл., УБ., 2024 он;

² Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3.3.2 дахь заалт;


улс орон дэлхийд өөрийн байр сууриа хадгалж, тогтвортой хөгжин дэвшсээр байна.

Монгол Улсад өнөөдрийн байдлаар бий болсон гаднын ямар нэгэн аюул, занал байхгүй хэдий ч олон улсын аюулгүй байдлын төлөв, чиг хандлага, гадаад, дотоод орчны өөрчлөлт, нөхцөл байдлыг байнга үнэлж, иргэдийн “Эх оронч” сэтгэлгээг нэмэгдүүлж, “Эх оронч үзэл”-ийг төлөвшүүлэх замаар “Үндэсний эв нэгдэл”-ийг хангаж, улс орны тогтвортой хөгжлийг дэмжиж, тулгарсан аливаа сорилт, бэрхшээлийг даван туулах чадавхыг бэхжүүлэх асуудал зүй ёсоор тавигдаж байна.

“Эх оронч үзэл” нь улс үндэстний эв нэгдэл, сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх, аливаа хямрал, сорилтыг даван туулах хүч болдог төдийгүй эх орон, ард түмэн, эх хэл, түүх, соёл, үндэстнийхээ үнэт зүйлсийг эрхэмлэн хүндэтгэж, хайрлан хамгаалах, эх орныхоо хөгжил, дэвшилд бодит хувь нэмрээ оруулах “Чин сэтгэл, зүтгэл”-ээр илэрдэг “Эх оронч хүн” бүрийн үзэл баримтлал болох учиртай.

“Монгол Улсын иргэн бүрийн үндэсний үнэт зүйлээрээ бахархагч, тэдгээрийг хайрлан хамгаалагч, тээн хөгжүүлэгч байх “Эх оронч үндэсний үзэл”, улс, үндэснийхээ ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахыг эрмэлзсэн идэвхтэй үйл ажиллагаа нь “Үндэсний аюулгүй байдал”-ыг хангах бодлого, үйл ажиллагааны “Эх үндэс” болно”³ гэсэн нь Монголын ард түмний “Эх оронч үзэлд суурилсан үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх”-ыг бэхжүүлэх үндэс суурь болно хэмээн үзэж байна.

“Эх оронч” гэж эх орон, түүх, эх хэл, соёл, өв уламжлал, зан заншил, үнэт зүйлээ эрхэмлэн дээдлэх ёс суртахуунт ухамсартай, хариуцлагатай “Ард түмэн”-ийг хэлэх бөгөөд түүний үзэл санаа нь *“тээн өвлөх, хайрлан хамгаалах, дэмжин хөгжүүлэх”* чин сэтгэл, зүтгэлээр илэрдэг байна. Энэ нь зөвхөн эх орондоо хайртай байх сэтгэл хөдлөл, *“хий хоосон цээжээ дэлдсэн, лоозон барьж хаширах”* төдий зүйл биш бөгөөд эх орныхоо хөгжил, дэвшилд бодит хувь нэмэр оруулах *“эгэл жирийн ард иргэдийн хариуцлагатай хандлага, тууштай хөдөлмөр, итгэл, үнэмшилд суурилсан хичээл зүтгэлийн үр шим, үр дүн”* болохыг харуулж байна.




1 дүгээр зураг. Эх оронч үзлийн үнэт зүйлс

Өнөө үеийн хүүхэд, залуучууд эх оронч үзлийг зөвхөн “Цэрэг” эх оронч үзэлтэй байж, “Цэрэг, арми” эх орноо хамгаалах үүрэг хүлээнэ

³ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.2.1 дүгээр хэсэг. 2010 он;

гэсэн өрөөсгөл ойлголттой байна. Иймд хүн бүрийг хүүхэд байхаас нь “Эх оронч үзэл”-ээр зөв төлөвшүүлж, иргэн бүр “Эх оронч үзэл”-тэй байхыг ухамсарлуулан ойлгуулах бүх нийтийн оролцоонд тулгуурласан бодлого боловсруулан хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага бий болж байна.

“Үндэсний эв нэгдэл” нь улс үндэстэн нэгдмэл зорилготой, нийтлэг үнэт зүйлс, тэгш ялгаваргүй эрх ашигтай байж, хамтдаа хөгжихийн төлөөх ухамсар, хандлага юм хэмээн тодорхойлж байна.



2 дугаар зураг. Үндэсний эв нэгдлийн үнэт зүйлс

Улс төр, нийгмийн бүхий л бүлэглэл нэг зорилгын дор зохицон нэгдэж, үндэсний өв соёл, үнэт зан заншил, уламжлалаа эрхэмлэн дээдэлж, улс эх орныхоо хөгжил, дэвшилд бодит хувь нэмэр оруулах “Эх оронч үзэл” төлөвшсөн иргэн бүрийн чин хүсэл, эрмэлзэл нь “Үндэсний эв нэгдэл”-ийн гол илрэл болдог.

Аливаа улс орны дотоод зөрчилдөөн ихсэж, “улс төр, нийгэм, эдийн засаг, шашин, соёлын ялгаатай бүлгүүдийн эв нэгдэл” хангагдаагүй бол улс эх орныхоо өмнө тулгамдсан аливаа сорилт, бэрхшээлийг даван туулах, тогтвортой хөгжих, бусад улс орнуудаас хараат бусаар оршин тогтнох боломжгүй юм.

Монгол Улсын хувьд улс орны хөгжил, аюулгүй байдал, тогтвортой байдал, олон улсын тавцан дахь байр сууриа хадгалж, хамгаалж, бэхжүүлэх үндэс, суурь нь “Үндэсний эв нэгдэл” болох төдийгүй хүн ам цөөн, хоёр том гүрний дунд оршдог манай улсын хувьд үндэсний эв нэгдлийг хангах явдал нь аюулгүй байдлын чухал стратеги болох учиртай юм.

Иймд манай улс нийт иргэдийнхээ эх оронч үзлийг төлөвшүүлэх замаар үндэсний эв нэгдлээ бэхжүүлж, аливаа сорилт, бэрхшээлийг хамтын хүчээр даван туулах чадавхаа бэхжүүлэх асуудлыг Төрийн бодлого, дэмжлэгтэйгээр бүх нийтийн оролцоонд тулгуурлан зохион байгуулах нь үр дүнтэй бөгөөд энэ чиглэлээр гаднын улс орнуудын туршлага, сургамжийг судалж, шинжлэх ухааны үндэслэлтэй гарц, шийдлийг тодорхойлох шаардлагатай байна.

Хоёр. “Эх оронч үзэлд суурилсан үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх”-ыг бэхжүүлэх арга зам, хүрэх үр дүн

Өнөө үед олон улсын хэмжээнд “Тогтвортой хөгжил” (Sustainability)-ийн зорилтуудтай зэрэгцэн “Resilience” гэх хямралыг даван туулах, үүссэн

хохирлыг шуурхай арилгаж, нөхөн сэргээх тухай шинэ ойлголтын талаар судлаач, мэргэжилтнүүд идэвхийлэн бичих болсон.

Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх (national resilience) гэдгийг судлаачид: улс орон аливаа дотоод, гадаад сорилтыг даван туулах, гаднын нөлөөнд өртөхгүй байх, тогтвортой хөгжих чадвартай байх нь үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх бэхжих боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Дэлхийн улс орнууд гэнэтийн нөхцөл байдалд дасан зохицож, уян хатан хариу үйлдэл үзүүлэх арга хэмжээний чадавх бүрдүүлэх, үүнд ард иргэдийг сургаж бэлтгэх талаар эрчимтэй судалгаа хийж, бодлого, төлөвлөгөө боловсруулах ажлыг эрчимжүүлж байна.

Энэ нь “Хүний аюулгүй байдал”-ыг хангахуйц улс төр, эдийн засаг, эрүүл мэндийн сайн тогтолцоотой, “эрсдэлийн менежмент”-ийн өндөр чадавхтай, улс орон аливаа эрсдэлийг амжилттай сөрөн тэсвэрлэж, богино хугацаанд хохирол багатайгаар даван туулна гэсэн үзэл санаанд тулгуурлаж байна.

Түүнчлэн дэлхий дахинд өрнөж буй үйл явдлуудаас харахад, бид ойрын ирээдүйд байгалийн болон олон улсын харилцааны ээдрээтэй нөхцөл байдал, шинэ эрсдэлтэй тулгарах, “байнгын эрсдэл”-тэй амьдралд дасан зохицох, хямралыг зохицуулах, бэрхшээлийг даван туулах сорилттой тулгарах нь зайлшгүй болж байна.

Монголчуудын хувьд энэхүү “Resilience” буюу “даван туулах” чадвар нь шинэ зүйл биш гэж хэлж болно. Гэвч сүүлийн үеийн байгаль цаг уурын өөрчлөлт, даяаршлаас үүдэлтэй улс орнуудын харилцан хамаарал, технологийн хөгжил, хотжилт зэрэг нийгмийн хүчин зүйлс нь Монголчууд бидний байгалийн хийгээд улс орны өмнө тулгамдсан сорилт, бэрхшээлүүдийг даван туулахад ихээхэн нөлөө үзүүлж, цаашид тэдгээрийг үндэсний эв нэгдлээ эрхэмлэн хамтын хүчээр, нэг санаа бодолтойгоор сөрөн тэсвэрлэхийг мөн нөхцөлдүүлж байна.

Гадаад улс орнуудын “Эх оронч үзэлд суурилсан үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх”-ыг бэхжүүлэхэд баримталж буй бодлого, үйл ажиллагаа

Дэлхийн олон улс орон “Энх тайван”, “Амар амгалан” оршин тогтнохын төлөө иргэдийн “Эх оронч үзэл”, хүмүүжлийг Төрийн бодлогоор хангаж, “Үндэсний эв нэгдэл”-ийг бататгаж, улс эх орноо болзошгүй гадаад, дотоодын аюул заналаас хамгаалах стратеги боловсруулан үндэсний давах туулах, сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэхэд онцгой анхаарал хандуулж байна. Тухайлбал: Япон, Финлянд зэрэг улс орнууд үндэсний соёл, үйлдвэрлэл, эдийн засгийн хараат бус байдлаа хадгалах, дэлхийн даяаршлын нөлөөнд автахгүйгээр өөрийн хэл, соёл, уламжлалт үнэт зүйлсээ хамгаалж, соёлын нөлөөллийг дэлгэрүүлэхэд “Эх оронч үзэл”-д суурилсан бодлого боловсруулан хэрэгжүүлж байна.

1 дүгээр хүснэгт. “Эх оронч үзэлд суурилсан үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх”-ыг бэхжүүлэхэд баримталж буй бодлого, үйл ажиллагаа

Д/д	Улс	Бодлого	Хэрэгжүүлж буй үйл ажиллагаа
1.	Япон	Япон хэл, бичгийн бодлого	- Япон хэлийг бүх салбарт ашиглаж, гаднын үг хэллэгийн хэт их нэвтрэлтийг хязгаарладаг. - Гаднын хэл дээрх контентыг Япон хэл рүү орчуулах хатуу журам мөрддөг. - Хүн бүрд бага наснаас нь эхлэн үндсэн хэл, бичгийн соёлыг түгээн дэлгэрүүлдэг. - Их сургуулийн элсэлтийн шалгалтад Япон хэл, соёл, түүхийн хичээлээр өндөр оноо авах шаардлага тавьдаг.
		Соёлын өвийг хадгалах бодлого	- Япон улс 1950 онд Соёлын өвийг хамгаалах хууль баталж, түүхэн дурсгалт газар, уламжлалт зан заншил, гар урлалыг хамгаалдаг. - Бүх шатны сургалтын байгууллагын заавал заах хичээлд Японы түүх, соёл, уламжлалын талаарх хичээлүүд багтдаг. - Хүн бүрд хүүхэд байхаас нь үндэсний ёс заншлыг эзэмшүүлж, Япон хүн байх бахархлыг ойлгуулдаг.
		Японы үндэсний үйлдвэрлэлийн бодлого	- “Made in Japan” брэндийг бэхжүүлэх замаар дэлхийд чанараараа тэргүүлэх өндөр технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, экспортын гол чиглэлээ болгосон. - Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлж, Засгийн газар үндэсний компаниудаа дэмжих, технологийн хөгжлийг тэргүүлэх салбар болгон хөгжүүлэхэд гол чиглэлээ болгож, дэлхийд тэргүүлэх стратеги хэрэгжүүлсэн. - Төрөөс жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж, тэдний бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд гаргах зорилгоор “One Village One Product” гэх мэт хөтөлбөр хэрэгжүүлдэг. - “Local Production, Local Consumption” бодлогын хүрээнд өөрийн орны хүнсний хангамжийг нэмэгдүүлэх замаар импортын бүтээгдэхүүнээс хэт хараат байдлыг бууруулж, дотоодын хөдөө аж ахуй, газар тариалан, мах, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж байна.
		Япон контентын бодлого	- Дотоодын телевиз, кино, анимэ, манга зэрэг соёлын бүтээгдэхүүнийг дэлхийд гаргах бодлого баримталж, гаднын контентын нэвтрэлтийг хязгаарладаг. - “Cool Japan” бодлогоор дамжуулан үндэсний соёлоо дэлхийд түгээн дэлгэрүүлж, гаднын соёлыг

			хэт давамгайлуулахаас сэргийлэхийн тулд үндэсний контент үйлдвэрлэлийг төрөөс санхүүжүүлж, хөгжүүлдэг.
2.	Финлянд	Мэдээллийн аюулгүй байдлын бодлого	- Мэдээллийн дархлааг нэмэгдүүлж, сэтгүүлч, төрийн албан хаагчдад зориулсан мэдээлэл боловсруулах, хянах чиглэлийн сургалт явуулдаг. - Улсын дэд бүтцийн систем, байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалдаг. - Хэвлэл мэдээллийн бие даасан байдлыг бий болгож, Үндэсний хэвлэл мэдээллийг дэмжих, гаднын нөлөөллөөс ангид байлгах зарчим баримталдаг.
		Иргэдийн мэдээллийн боловсролыг нэмэгдүүлэх бодлого	- Бүх шатны сургалтын хөтөлбөрт бага ангиасаа эхлэн мэдээлэл унших, шалгах, эх сурвалжийг үнэлэх, мэдээллийн аюулгүй байдлын хичээлүүдийг тусган заадаг. - Бүх нийтийн мэдээллийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр Засгийн газраас иргэдэд зориулсан мэдээллийн боловсролын сургалт зохион байгуулдаг.
		Кибер аюулгүй байдлыг хангах бодлого	- Төрийн болон хувийн байгууллагуудтай хамтран ажиллаж, цахим халдлагаас хамгаалах хяналтын системийг хөгжүүлсэн. - Төрийн байгууллагууд мэдээллийн хамгаалалтын стандарт, кибер аюулгүй байдлын өндөр шаардлага хангасан систем ашигладаг.
		Гаднын суртал ухуулга, худал мэдээлэлтэй тэмцэх	- Гадаадын суртал ухуулга, хуурамч мэдээлэлтэй тэмцэх чиглэлээр гаднын улс орнуудын улс төр, нийгмийн тогтвортой байдалд нөлөөлөх оролдлогоос зайлсхийдэг. - Олон нийтийн платформ дээрх хуурамч мэдээлэлтэй тэмцэх зорилгоор төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд хамтран ажилладаг.

Судалгаанаас харахад: Япон улс нь өөрийн үндэсний соёл, үйлдвэрлэл, эдийн засгийн хараат бус байдлаа хадгалж чадсаны гол хүчин зүйл нь “Соёлын дархлаа буюу үндэсний өв соёлоо хамгаалж, хөгжүүлэх бодлого” болон “Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих стратеги” боловсруулж хэрэгжүүлсэнд оршиж байна. Түүнчлэн Финлянд улс нь үндэстнийхээ эв нэгдлийг хангаж, гаднын мэдээллийн нөлөөлөл, цахим халдлага, худал мэдээлэл (disinformation)-ийн эсрэг бодлого хэрэгжүүлсэн нь мэдээллийн аюулгүй байдал, цахим хамгаалалт, олон нийтийн мэдээллийн боловсролын төвшнөөр дэлхийд тэргүүлэх үндэслэл болжээ.

Дээрх хоёр улсын “Эх оронч үзэлд суурилсан үндэсний сөрөн тэсвэрлэх

чадавх”-ыг бэхжүүлэхэд баримталж буй бодлого, үйл ажиллагаа нь хоёр том гүрний дунд орших манай улсын нөхцөл байдалд илүүтэй тохирно хэмээн үзэж байна. Энэ нь манай улс *“хүн бүрд хүүхэд байхаас нь үндэсний түүх, эх хэл, өв соёл, зан заншил, уламжлалыг боловсролоор дамжуулан олгох”* бодлого боловсруулан бүх нийтийн оролцоотойгоор тууштай, үр дүнтэй хэрэгжүүлж, *“Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх”*-аа бэхжүүлж чадвал дээрх хоёр улсын жишгээр улс эх орныхоо тогтвортой хөгжлийг хангах боломж бүрдэх ач холбогдолтой гэж үзэж байна.

“Эх оронч үзэлд суурилсан үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх”-ыг бэхжүүлэхэд тулгамдаж буй асуудал

Өнөө үед Монгол Улсын өмнө *“Эх оронч үзэл”*-ийг төлөвшүүлэх, мөн *“Үндэсний эв нэгдэл”*-ийг бэхжүүлэхэд дараах асуудлууд тулгамдаж байна. Тухайлбал:

1. *“Эх оронч үзлийг дэмжих боловсролын тогтолцоо”* хангалттай хөгжөөгүй байгаа нь үндэсний түүх, соёлын ач холбогдлыг залуу үед таниулж, эх оронч үзлийг төлөвшүүлэх боломжийг хязгаарлаж, хүүхэд, залуучуудад *“Эх оронч үзэл”* нь хэт хуучирсан, зөвхөн цэрэг, армийн асуудал гэсэн буруу ойлголтыг өгч, хэрэгцээгүй мэдээ, мэдээлэлд суурилсан *“Тархи угаалт”*-ыг бий болгож байна.

2. *“Хот, хөдөөгийн хөгжлийн ялгаатай байдал”* үлэмж нэмэгдэж, нийгмийн эрх тэгш бус байдал Төр, ард иргэдийн дунд *“Зохиомол зөрчил”* үүсгэж, *“Үндэсний эв нэгдэл”*-ийг хагаралдуулж, ядуурал, ажилгүйдлийг далимдуулан үндэстний *“Эх оронч үзэл”*, *“Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх”*-т сөргөөр нөлөөлж байна.

3. *“Улс төрийн нам, бүлэглэлүүдийн зөрчилдөөн, хэт туйлширал”* нь иргэдийн Төрдөө итгэх итгэл, үнэмшлийг бууруулж, улс эх орны хөгжлийг гацаах *“компанит ажил”* явуулж, нийгмийн эв нэгдлийг *“зориудаар”* сулруулж, ард иргэдийн дунд *“зохиомол зөрчилдөөн”* үүсгэж, *“Эх оронч сэтгэлгээ”*-нд сөргөөр нөлөөлж байна.

4. *“Төрийн шийдвэр гаргалт”* улс төрийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, хяналт дутмагшиж, аливаа шийдвэр гаргалтад хуулийн засаглал болон шударга ёс хангалтгүй байгаагаас улс төр, нийгмийн идэвхтэй оролцоо буурч, бүх шатанд авлига, *“эрх мэдлийн төлөөх тэмцэл”* ихсэж байна.

5. *“Монгол Улсын эдийн засгийн чадамж”* хөрш орнууд болон дэлхийн зах зээлээс ихээхэн хамааралтай байгаа нь *“Эх оронч-үйлдвэрлэл”*, дотоодын бизнесийг хөгжүүлэхэд саад болж, дотоодын үйлдвэрлэл хэрэгцээгүй мэт ойлголтыг төрүүлж, *“эдийн засгийн дархлаа”*-г сулруулах эрсдэл үүсгэж байна.

6. *“Гадаад соёл, үзэл суртлын нөлөөлөл”* нь *“Үндэсний үнэт зүйл”*, *“Эх*

оронч үзэл”, үндэсний бахархал, ухамсрыг сулруулж, хүүхэд, залуучуудын гаднын хэв маягийг даган дуурайх байдал давамгайлах болсон нь “асар их үнээр олдсон эх түүх”-ийн үнэ цэн алдагдаж, “Монгол бахархал”-ыг сулруулж, гадаад соёлд хэт автсан “Ондоошил”-ийг бий болгож байна.

7. “Байгалийн нөөцийн хэт ашиглалт” уул уурхай, ой хээрийн түймэр зэрэг асуудлууд нь байгаль орчныг сүйтгэж, энэ нь зөвхөн экосистемд төдийгүй иргэдийн сэтгэл зүйд болон эх орноо хайрлан хамгаалах “Сэтгэлгээ”-нд сөргөөр нөлөөлж байна.

Дээрх тулгамдсан асуудлуудыг даван туулахын тулд дараах арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэх нь зүйтэй.

2 дугаар хүснэгт. “Эх оронч үзэлд суурилсан үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх”-д тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам

№	Тулгамдсан асуудал	Шийдвэрлэх арга зам	Хүрэх үр дүн
1.	Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт “Эх оронч үзэл”-д суурилсан заавал судлах хичээлийн агуулгыг оруулах	1. “Монголын түүх”, “Өв соёл, уламжлал” зэрэг хичээлүүдийг оруулж, хичээлийг орчин үеийн арга барилаар зааж, үндэсний бахархлыг төрүүлэх; 2. ЕБС, их, дээд сургуульд эх оронч сэтгэлгээг хөгжүүлэх “Эх оронч суралцагч” клуб байгуулж, үйл ажиллагааг нь дэмжих.	“Хүн бүрд хүүхэд байхаас нь эх оронч үзэл”-ийг төлөвшүүлэх, эв нэгдлийг хангах, улс эх орны тогтвортой хөгжих боломж бүрдэнэ.
2.	Байгаль орчныг хамгаалахад чиглэсэн “Эх оронч хөдөлгөөн”-ийг дэмжиж, байгалийн баялгийг зохистой ашиглах бодлого хэрэгжүүлэх	1. Хүүхэд, залуучуудын оролцоонд тулгуурласан “Байгаль хамгааллын аян”-ыг улс орон даяар өрнүүлэх; 2. Хүүхэд, залуучуудын эв нэгдлийг хангасан байгаль хамгааллын сургалт зохион байгуулах; 3. “Эх оронч Монгол” үндэсний хөтөлбөрийг боловсронгуй болгож, бүх нийтийн боловсролтой уялдуулан шинэчлэн батлах. 4. “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ийг тойрон аялал хэлбэрээр зохион байгуулах.	Байгаль орчныг хамгаалахад чиглэсэн “Эх оронч хөдөлгөөн”-ийг дэмжиж, байгалийн баялгийг зохистой ашиглах бодлогыг хэрэгжүүлснээр хүүхэд, залуучуудын “Эх оронч сэтгэлгээ” өсөн нэмэгдэнэ.

3.	Үндэсний үйлдвэрлэл, жижиг дунд бизнесийг хөгжүүлэхэд “эдийн засаг”-ийн болоод “Эх оронч үйлдвэрлэл”-д бодит дэмжлэг үзүүлэх	1. Төрөөс жижиг, дунд бизнесийг дэмжиж, “Local Production, Local Consumption” санаачилгыг хэрэгжүүлэх; 2. Хүнсний бүтээгдэхүүний импортыг бууруулах бодлого баримталж, “Эх оронч-Үндэсний үйлдвэрлэгч” хөтөлбөр хэрэгжүүлэх; 3. Үндэсний технологийн салбарыг хөгжүүлж, хөдөө аж ахуйн салбарт өндөр технологи, инновацыг нэвтрүүлэх.	Үндэсний хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа өргөжнө.
4.	Монгол өв, соёлын “дархлаа”-г нэмэгдүүлэх замаар хүүхэд, залуучуудад “Эх түүх, өв соёл, зан заншил”-ыг түгээн дэлгэрүүлэх	1. “Монгол хэл, соёл, үндэсний өв уламжлалаа хамгаалах бодлого” боловсруулж, хэрэгжүүлэх; 2. “Үндэсний контент үйлдвэрлэл” (кино, дуу хөгжим, социал медиа)-ийг хөгжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх; 3. Гаднын соёлын нөлөөллийг зохицуулах замаар “Үндэсний үнэт зүйл” реалити шоу зохион байгуулах.	Монгол хүний ухамсарт амьдрал, уламжлалт зан заншил, өв тэгш хүмүүжлийн талаарх контент, подкаст, рийл хийж, “хотжилт”, “хөдөөжилт” гэсэн үзэл бодлын ялгавартай байдлыг бууруулах замаар “Гаднын соёл”-д хэт автах сэтгэлгээг арилгах боломж бүрдэнэ.
5.	Гадаад соёлын сөрөг нөлөөллөөс хамгаалах, “Үндэсний үнэт зүйлс”-ийг түгээх мэдээллийн хөтөлбөрүүдийг бий болгох	1. “Эв нэгдэл, эх оронч үзэл”-ийг дэмжсэн “контент, нэвтрүүлэг, подкаст” нийтлэлийг нэмэгдүүлэх; 2. “Худал мэдээлэл, хагарал үүсгэгч контенттой тэмцэх хууль”, холбогдох дүрмийг боловсронгуй болгох. 3. Сошиал орчинд залуучуудын “Зөв хандлагыг төлөвшүүлэх сургалт зохион байгуулах”; 4. Гадаадад амьдарч буй “Монголчуудын эх орон”-тойгоо холбоотой байх боломжийг дэмжих.	Сошиал медиаг зөв зохистой ашиглах соёлыг түгээж, мэдээллийн аюулгүй байдлыг хангана.

3 дугаар хүснэгт. “Эх оронч үзэлд суурилсан үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх”-ыг бүрдүүлэх арга зам

№	Асуудал	Шийдэл
1.	Эх оронч үзлийг төлөвшүүлэх	Түүх, соёлын боловсролыг нэмэгдүүлэх 1. Монголын түүх, тусгаар тогтнолын төлөөх тэмцэл, үндэсний баатруудын үйл хэргийг сурталчлах. 2. Түүхийн ухаарал өгсөн ном, кино, баримтат бүтээлүүдийг түгээх, хэлэлцүүлэг хийх. 3. Үндэсний бахархлыг төрүүлэх түүхэн баяруудыг ач холбогдолтойгоор тэмдэглэх.
		Иргэний үүрэг, хариуцлагыг ухамсарлуулах 1. Үндэсний эв нэгдлийг хангах, ард иргэдийн ухамсрыг дээшлүүлэх сургалтууд зохион байгуулах. 2. Иргэдийг улс төрийн идэвхтэй оролцоотой болгож, үндэсний эрх ашгийг ойлгуулж, соён гэгээрүүлэх.
2.	Улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдлаа сахин хамгаалах чадварыг хөгжүүлэх	Батлан хамгаалах боловсролыг түгээх 1. “Эх оронч үзэл” төлөвшүүлэх сургалтуудыг ЕБС, их, дээд сургуулийн хөтөлбөрт түлхүү оруулах. 2. “Монгол цэрэг-Дэлхийн бахархал” зэрэг сэдэвт арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулах. 3. Цэрэг-спортын наадам, тактикийн сургалтуудыг залуучуудын дунд зохион байгуулах.
		Гамшиг, онцгой байдлын үед сөрөн зогсох чадварыг нэмэгдүүлэх 1. Иргэдэд бие даах чадвар олгох, өөрийгөө болон бусдыг хамгаалах тактикийн сургалт явуулах. 2. Онцгой байдлын үед хэрхэн хариу арга хэмжээ авах талаар олон нийтэд ойлголт өгөх.
3.	Үндэсний эдийн засгийн дархлааг нэмэгдүүлэх	Дотоодын үйлдвэрлэл, хүнсний аюулгүй байдлыг хангах 1. Монголын үндэсний үйлдвэрлэл, газар тариалан, мал аж ахуйг дэмжих бодлого хэрэгжүүлэх. 2. Стратегийн бүтээгдэхүүн (гурил, мах, шатахуун, эм, эрчим хүч)-ий дотоодын нөөцийг нэмэгдүүлэх.
		Эдийн засгийн хараат бус байдлыг хангах 1. Гадаад худалдааны тэнцвэрийг хадгалах, дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих. 2. Гадаадын хөрөнгө оруулалтыг үндэсний эрх ашигт нийцүүлэх.

4.	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, үзэл суртлын хамгаалалтыг сайжруулах	Үндэсний үнэт зүйлсийг хамгаалах 1. Соёлын дархлаа бий болгох, гадаадын хэт нөлөөнөөс сэргийлэх бодлого хэрэгжүүлэх. 2. Эх хэл, үндэсний уламжлал, соёлын өвийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх.
		Хуурамч мэдээлэл, сөрөг нөлөөллөөс хамгаалах 1. Иргэдэд үнэн зөв мэдээлэл түгээх, мэдээлэл боловсруулах чадварыг хөгжүүлэх. 2. Гадаадын зохион байгуулалттай үзэл суртлын нөлөөлөл, худал мэдээллийн эсрэг арга хэмжээ авах.
5.	Нийгмийн эв нэгдлийг бэхжүүлэх	Олон нийтийн харилцааг сайжруулах, зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх 1. Иргэдийн эв нэгдлийг хангах, талцлаас ангид байлгах бодлого баримтлах. 2. Үндэсний эв санааны нэгдлийг нэмэгдүүлэх зорилгоор соёл, спорт, урлагийн арга хэмжээнүүдийг зохион байгуулах.
		Шударга ёс, хууль дээдлэх үзлийг төлөвшүүлэх 1. Авлига, хээл хахуулийг бууруулах, хууль сахиулах байгууллагуудын хариуцлагыг нэмэгдүүлэх. 2. Иргэдэд хууль, эрх зүйн боловсрол олгох сургалтуудыг тогтмол зохион байгуулах.

Дүгнэлт

Эх оронч үзлийн уламжлалт хандлага шинэчлэгдэж, урьд өмнөх төсөөллийг шинэ агуулгаар тайлбарлах хэрэгтэй болж байна.

Монголчуудын эх оронч үзэл, хүмүүжлийн талаарх нийгмийн оюун санааны өв санг судлан шинжлэх ухааны эргэлтэд оруулах нь бүх нийтийн тулгамдсан зорилт болж, улмаар хүүхэд, залуучуудын эх оронч үзэл, хүмүүжлийн тогтолцоог цаашид улам боловсронгуй болгон төрөөс хүүхэд, залуучуудын талаар баримтлах бодлогыг боловсруулах, нөгөө талаар хувь хүн ба нийгмийн оюун санааны бие даасан байдлыг хангаж, иргэд, залуучуудад эх орноо хайрлах, бахархах үзэл санааг төлөвшүүлэхгүйгээр улс орны аюулгүй байдал, тусгаар тогтнолыг хангах боломжгүй гэдгийг судалгааны үр дүн харуулж байна.

Түүнчлэн манай улсын хүүхэд, залуучуудын 20,7 хувь нь “Эх оронч үзэл”-ийн талаарх ойлголт байхгүй, 60,2 хувь нь “ЭХ ОРОНЧ ҮЗЭЛ”-ийг зөвхөн “ЦЭРЭГ, АРМИ”-ийн асуудал хэмээн ойлгож, үлдсэн хувь нь эх оронч үзэл бол иргэн бүрийн шууд оролцооноос хамаарна гэжээ. Энэ нь манай улсад хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх чиглэлээр

цөөнгүй тооны хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр батлагдсан ч үр дүн нь зорилтод түвшиндээ хүрээгүй байгааг харуулж байна. Иймд хүн бүрд хүүхэд байхаас нь эх оронч үзлийг төлөвшүүлэх, баталсан хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг чанаржуулах шаардлагатай байна.

Мөн дэлхийн олон улс орон өнөө үед явагдаж буй дайн, зэвсэгт мөргөлдөөн, их гүрнүүдийн геополитикийн сөргөлдөөнөөс үүдэлтэй гадаад, дотоод орчны аюулгүй байдлын сорилт, бэрхшээлүүд улс үндэстэн бүрийг үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхтай байхыг шаардаж байна.


Энэ нь нэгд, олон улсын геополитикийн нөхцөл байдлаас үүдэлтэй аюулгүй байдлын орчны тогтворгүй байдал нэмэгдсэн; хоёрт, дайн, тэмцлийн хэлбэр, арга өөрчлөгдөж “хосолмол дайн”-ы шинж чанартай явагдах болсон; гуравт, нийтийг хамарсан цар тахал, байгалийн гамшгийн давтамж нэмэгдэх болсон зэрэгтэй холбоотойгоор улс орон бүрд эрсдэл үүсгэж эхлээд байна.

Үүнд манай улс аливаа эрсдэл, сорилт бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, даван туулах гэсэн үзэл санаанд тулгуурлаж, “Эх оронч үзэлд суурилсан үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх”-ын үзэл баримтлал бүхий стратеги боловсруулах нь зүйтэй хэмээн дүгнэж байна.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл

1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 2010, 2011 он;
2. Б.Чимэд., “Үндсэн хуулийн мэдлэг”. УБ., 2008. Т-36;
3. С.Нарангэрэл., “Чингис хааны ёс суртахууны эрх зүйн шастир”. УБ., 2014. Т-17;
4. “Монголчуудын үнэт зүйл судалгааны тайлан”. УБ., 2019. Т-75;
5. Ц.Амарсанаа “Хүний генетикийн шинжилгээ, оношилгооны хууль зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа”. 2024 он;
6. Ч.Эрдэнэчулуун. “Үндэсний эв нэгдлийн тулгамдсан асуудал, бэхжүүлэх зарим асуудалд” өгүүлэл., “АББСС-№37”. УБ., 2024 он;
7. Монгол Улсын Шинжлэх ухааны академи. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Х-Я. х. 3225. Улаанбаатар. 2008 он;
8. Gellner, E. Nations and Nationalism. Blackwell. 1983;
9. Smith, A. Ethno-symbolism and Nationalism: A Cultural Approach. Routledge. 2009.

“ХҮН БҮРД ХҮҮХЭД БАЙХААС НЬ ЭХ ОРОНЧ ҮЗЭЛ ТӨЛӨШҮҮЛЭХ” ҮЕ ШАТ



“ЭХ ОРОНЧ ҮЗЭЛД СУУРИЛСАН ҮНДЭСНИЙ СӨРӨН ТЭСВЭРЛЭХ ЧАДАВХ”-ЫГ БЭХЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

